

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ
2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2026.06.04

№	Гүйцэтгэх ажил, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилт
Зорилт 1: Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах хүрээнд							
1.1	Албан хаагчдыг гадаад, дотоодын их, дээд сургуульд сурах, мэргэшил дээшлүүлэх, сургалтад хамрагдах хугацаанд цалин, урамшууллыг олгож дэмжлэг үзүүлэх, чөлөө олгох	Улсын төсөв	Сургалтын чөлөө авсан албан хаагчийн тоо	30	32	01-12 сар	УБЕГ-ын даргын тушаалаар сургалтын цалинтай чөлөө олгосон 8 албан хаагч байна. Аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст дотоод зохион байгуулалт хийж 21 албан хаагчид мэргэшил дээшлүүлэх суралцах нөхцлөөр ханган ажилласан байна. Хэрэгжилт 80 хувь
1.2	Албан хаагчдад олгох үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн шинэчлэн тогтоох	Улсын төсөв	Цалин хөлс нэмэгдүүлсэн албан хаагчдын тоо	-	470	01-12 сар	2025 оны Засгийн газрын “Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын хэрэгжилтийг ханган УБЕГ-ын төрийн захиргааны 94, дүүргийн УБХ-ийн 377 нийт 471 албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг УБЕГ-ын даргын 2026 оны Б/33 дугаар тушаалаар нэмэгдүүлсэн. Хэрэгжилт 100 хувь
1.3	Албан хаагчдыг хариуцсан албан үүргийн чиглэлээр мэргэшлийн зэрэг, зэрэг дэв шинээр олгуулах, ахиулах	Улсын төсөв	Зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон албан хаагчдын тоо	417	536	01-12 сар	Монгол Улсын их хурлын 2019 оны 21-р тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилтийг ханган УБЕГ-ын даргын 2026 оны Б/108 дугаар тушаалаар 33 албан хаагчид шинээр, 86 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгож нийт 119 албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг шинэчлэн олгон ажилласан. Хэрэгжилт 100 хувь
1.4	Сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулж, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх	Төсөвгүй	Сул орон тоог нөхсөн тоо	25	30	01-12 сар	Сул орон тоог нөхөх 3 удаагийн шилжин, сэлгэх зар, төрийн албан хаагчийн тусгай шалгалтын ажлыг зохион байгуулж, 37 орон

							тоог нөхөн томилж албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт 100 хувь
Зорилт 2. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, ажлын байрны орчин, нөхцөлийг дээшлүүлэх хүрээнд							
2.1	Албан хаагчдыг ажиллах нөхцөл, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр ханган ажиллах	Төслийн болон бусад санхүүжилт	Шаардлагатай техник хэрэгсэлээр хангагдсан тоо	153	165	01-12 сар	Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулан Азийн хөгжлийн банкны санхүүжилт, бусад төрийн байгууллагын дэмжлэгтэйгээр 8,100,000 мянган төгрөгний төсвөөр ажлын байранд засвар үйлчилгээ хийсэн, шаардлагатай техник, тоног төхөөрөмж болох зөөврийн компьютер-30, суурин компьютер-30, принтер-23, скайнер 12, авто машин-4-ыг Хөвсгөл, Архангай, Завхан, Дорнод аймагт тус тус олгон ажилласан байна. Хэрэгжилт 80 хувь
2.2	Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах	Улсын төсөв	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан албан хаагчийн тоо	200	200	01-12 сар	Аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан өрх, дүүрэг, аймгийн эмнэлэгтэй хамтран албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 120 албан хаагчийг хамруулан ажилласан байна. Хэрэгжилт 60 хувь
2.3	Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор спортын арга хэмжээ зохион байгуулах	Улсын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	2	01-12 сар	Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагчдийн дунд 2026 оны 1-р улиралд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан. 2026 оны 2-р улиралд иогийн сургалтыг 7 хоногийн 3 өдөр зохион байгуулан албан хаагчид хамрагдаж байна. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдсан “Эрүүл мэндийн жим-өглөөний алхалт”-д 1 сарын аянд оролцсон. Хэрэгжилт 80 хувь
Зорилт 3. Албан хаагчдын амьдралын нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх хүрээнд							

3.1	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тусламж үзүүлэх	40 сая	Тусламж, дэмжлэг хүссэн албан хаагчдын тоо	50	50	01-12 сар	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу УБЕГ-ын даргын тушаалаар нийт 18 албан хаагчид 9,016,700 төгрөгийн тусламж олгосон. Хэрэгжилт 40 хувь
3.2	Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч, асаргаа шаардлагатай хүүхэдтэй албан хаагчдын ажлын цаг богиносгох	Төсөвгүй	Ажлын цаг богиносгох дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан албан хаагчдын тоо	-	25	01-12 сар	Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймаг дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчид, хөгжлийн бэрхшээлтэй, асаргаа шаардлагатай хүүхэдтэй албан хаагчдын ажлын цагийг 7 хоногт 4 цагаар богиносгох тухай Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/40 дүгээр тушаал батлагдан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд хүсэлт гарган ажлын цагийг богиносгон ажиллаж байгаа 26 албан хаагч байна. Хэрэгжилт 100 хувь
3.3	Амьдрах орон байр нь дулаан хангамжийн төвлөрсөн системд холбогдоогүй галлагаа шаардлагатай нөхцөлд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлэх мөнгөн тусламж үзүүлэх	Төсөвт тусгагдаагүй	Мөнгөн тусламж олгосон албан хаагчдийн тоо	-	25	10-12 сар	Хэрэгжилтийн хугацаа 3,4-р улиралд

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээтэй УБЕГ-ын даргаар 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр батлуулан, аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргэгдэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2026 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлт 74 хувийн хэрэгжилттэй байна.